

**БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН БОЛОН САНХҮҮГИЙН БУС БИЗНЕСИЙН  
МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТОХИРОМЖТОЙ ЭТГЭЭДИЙГ  
ТОДОРХОЙЛОХ ЖУРАМ /ТӨСӨЛ/**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1-д заасан санхүүгийн болон санхүүгийн бус бизнесийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх хүсэгч, хуулийн этгээд, хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, эрх бүхий албан тушаалтан, энгийн хувьцааны 10 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг эсхүл эзэмших хүсэлт гаргасан, салбар төлөөлөгчийн газрын эрх бүхий албан тушаалтан, Хадгаламж зээлийн хоршооны тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хороо, банк бус санхүүгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэгчийн агент, үл хөдлөх хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдийн агент, брокер, үнэт металл, үнэт чулууны арилжаанд оролцогч этгээдийн хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтныг тохиромжтой этгээд эсэхийг тодорхойлж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулахад оршино.

1.2. Энэхүү журам нь дотоодын болон гадаадын хуулийн этгээдийн нэгдлийн оролцогч, толгой компанид мөн адил үйлчилнэ

**ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ**

2.1. Энэхүү журам нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1.2-4.1.8-д заасан мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд хамаарна.

2.2. Хороо дор дурдсан хувь хүн, хуулийн этгээдэд энэхүү журмын дагуу тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаж байгаа эсэхэд хяналт тавина.

2.2.1. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1-д заасан санхүүгийн үйлчилгээнд хамаарах үйл ажиллагаа, эсхүл санхүүгийн бус бизнесийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргагч эрх бүхий албан тушаалтан, Хадгаламж зээлийн хоршооны тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хороо;

2.2.2. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1-д заасан санхүүгийн үйлчилгээнд хамаарах үйл ажиллагаа, эсхүл санхүүгийн бус бизнесийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын удирдлага;

2.2.3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасан эцсийн өмчлөгч;

2.2.4. Хуулийн этгээдийн энгийн хувьцааны 10 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг эсвэл эзэмших хүсэлт гаргасан этгээд; (хувьцаа эзэмшигч эсхүл хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахаар хүсэлт гаргасан этгээд)

2.2.5. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий банк бус санхүүгийн байгууллагын агент.

2.2.6. Үл хөдлөх хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдийн агент, брокер;

2.2.7. Үнэт металл, үнэт чулууны арилжаанд оролцогч этгээдийн хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүл, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтан;

2.3. Энэхүү журмын 2.2-т заасан этгээдүүдэд дараах тохиолдолд тохиромжтой байдлын шалгуур үйлчилнэ. Үүнд:

2.3.1. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, Хадгаламж, зээлийн хоршооны тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлтэй үйл ажиллагаа эрхлэх, эсхүл тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл авах;

2.3.2. Энэхүү журмын 2.2-т заасан хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах;

2.3.3. Эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдөх;

2.3.4. Хороо энэхүү журмын 2.2-т заасан хуулийн этгээдийг Тохиромжтой этгээд эсэхийг холбогдох төрийн байгууллага болон гадаадын эрх бүхий байгууллагын мэдээлэлд үндэслэн тодорхойлж болно.

### **ГУРАВ. ТОХИРОМЖТОЙ ЭТГЭЭДИЙН ШАЛГУУР**

3.1. Энэхүү журмыг 2.2-т заасан этгээд дараах шалгуурыг хангасан тохиолдолд Хороо тохиромжтой этгээд гэж үзнэ. Үүнд:

3.1.1. Мэдлэг боловсрол, ажлын туршлагатай байх;

3.1.2. Санхүүгийн байдал хэвийн байх;

3.1.3. Гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх;

3.1.4. Бизнесийн болон ёс зүйн нэр хүндтэй байх;

3.1.5. Ашиг сонирхлыг зөрчлөөс ангид байх;

3.1.6. Хуульд заасан бусад.

3.2. Хуулийн этгээд нь оффшор буюу татвараас чөлөөлөгдөх бүсэд үндсэн харьяалалтай байхыг хориглоно.

3.3. Эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдөх тохиолдолд хэрэв түр орлон гүйцэтгэх этгээд томилогдвол тухайн этгээд мөн тохиромжтой этгээдийн шалгуур хангасан байна.

3.4. Энэхүү журмын 2.2-т заасан этгээд нь хувь хүн бол түүнд энэхүү журмын 4.2-т заасан шалгуурууд хамаарахгүй.

3.5. Энэхүү журмын 2.2-т заасан этгээдийн хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол түүнд энэхүү журмын 4.5-т заасан шалгуурууд хамаарахгүй.

3.6. Салбар, төлөөлөгчийн газар эсвэл охин компаниараа дамжуулан Монгол Улсад үйл ажиллагаа явуулах эрхтэй гадаад улсын мэдээлэх үүрэгтэй этгээдийн удирдлагад энэхүү журмын 4 дүгээр бүлэгт заасан тохиромжтой байдлын шалгуур хамаарна.

## **ДӨРӨВ. ТОХИРОМЖТОЙ ЭТГЭЭДИЙН ШАЛГУУРЫГ ТОДОРХОЙЛОХ**

4.1. Энэхүү журмын 3.1.1-д заасан “Мэдлэг боловсрол, ажлын туршлагатай байх” шалгуурыг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлно. Үүнд:

*Санхүүгийн байгууллагын хувьд:*

4.1.1. Төлөөлөн удирдах зөвлөл, эцсийн өмчлөгч, гүйцэтгэх удирдлага, салбарын удирдлага зэрэг эрх бүхий албан тушаалд томилогдох этгээдүүд нь:

- 1) Банк, санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг, хууль, эрх зүйн чиглэлээр их, дээд сургууль төгссөн байх;
- 2) Тухайн албан тушаалд дүйцэхүйц албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- 3) Санхүүгийн салбарт 3-аас доошгүй жил ажилласан байх;

4.1.2. Тэргүүлэгчдийн зөвлөл болон Хяналтын зөвлөл, зээлийн хороонд томилогдох этгээдүүдийг Хадгаламж зээлийн хоршооны тухай хуулийн 34.3, 34.4, 34.11-г заасан шаардлагын дагуу тавина;

4.1.3. Агент нь:

- 1) Банк, санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг, хууль, эрх зүйн чиглэлээр их, дээд сургууль төгссөн байх;
- 2) Санхүүгийн салбарт 3-аас доошгүй жил ажилласан байх

*Санхүүгийн бус бизнесийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн хувьд:*

4.1.4. Төлөөлөн удирдах зөвлөл, эцсийн өмчлөгч, салбарын удирдлага зэрэг эрх бүхий албан тушаалд томилогдох этгээдүүд нь:

- 1) Их дээд сургууль, коллеж эсхүл техникум төгссөн байх;
- 2) Хорооноос мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулдаг сургалтад сууж, сертификат авсан байх;

4.2. Энэхүү журмын 3.1.2-т заасан “Санхүүгийн байдал хэвийн байх” шалгуурыг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлно. Үүнд:

4.2.1. Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэлгүй байх;

4.2.2. Энэ журмын 2.2-г заасан хуулийн этгээдийн хувьд сүүлийн 2 жил төлбөрийн чадваргүй болоогүй байх;

4.3. Энэхүү журмын 3.1.3-т заасан “Гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх” шалгуурыг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлно. Үүнд:

4.3.1. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй;

4.3.2. Хүсэлт гаргах үед сахилгын эсвэл эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдаагүй, шүүх хуралд шүүгдэгчээр, хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын шатанд сэжигтнээр оролцоогүй байх;

4.4. Энэхүү журмын 3.1.4-т заасан “Бизнесийн болон ёс зүйн нэр хүндтэй байх” шалгуурыг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлно. Үүнд:

4.4.1. Сүүлийн 5 жилийн хугацаанд өөрийн буруутай үйлдлээс, ёс зүйн дүрмийг зөрсөнөөс үүдэн Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу ажлаас халагдах арга хэмжээ авхуулаагүй байх;

4.4.2. Хорооны зохицуулалтанд хамрагдах санхүүгийн үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой үүссэн гомдлын хариуцагч биш байх;

4.4.3. Монгол Улс болон гадаад улсын нутаг дэвсгэрт хууль, журам, бизнесийн ёс зүй, дүрмийг зөрсөн эсэх, бусдад энэхүү үйлдлийг хийхэд тусалсан хэрэгт холбогдоогүй байх;

4.4.4. Монгол Улсын болон гадаад улсын нутаг дэвсгэрт зохицуулалтын аливаа шаардлагыг хангахад, эсхүл мэргэжлийн болон ёс зүйн аливаа стандартыг дагаж мөрдөхөд бэлэн байх.

4.5. Энэхүү журмын 3.1.5-д заасан “Ашиг сонирхлыг зөрчлөөс ангид байх” шалгуурыг дараах үзүүлэлтүүдээр тодорхойлно. Үүнд:

4.5.1. Хороо, түүний Хяналтын зөвлөлийн дарга, гишүүд, Хорооны Ажлын албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, эрх бүхий албан тушаалтан биш байх;

4.5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд харшлаагүй байх;

4.5.2. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1-д заасан санхүүгийн үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааг зохицуулсан тусгайлсан хуульд харшлаагүй байх;

## **ТАВ. ТОХИРОМЖТОЙ ЭТГЭЭДИЙН ШАЛГУУР ХАНГАСАН ЭСЭХИЙГ ТОДОРХОЙЛОХ БАРИМТ БИЧГИЙГ БҮРДҮҮЛЭХ**

5.1. Хороо энэхүү журамд дурдсан тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаж байгаа эсэхийг тодорхойлохдоо шаардлагатай нотлох баримтыг цуглуулна. Монгол Улсын болон гадаад улсын Засгийн газрын агентлаг, төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, зохицуулалтын бусад байгууллага, цагдаагийн байгууллага зэрэг холбогдох байгууллагуудаас мэдээлэл, лавлагаа авч болно.

5.2. Энэхүү журмын 2.2-т заасан этгээд тохиромжтой этгээд болохоо нотлох баримтыг бүрдүүлж Хороонд ирүүлнэ.

5.3. Хороо энэхүү журмын хавсралт 1-д дурдсан “Асуулгын хуудас”-ыг бөглүүлнэ.

5.4. Хороо шаардлагатай гэж үзвэл энэхүү журмын 2.2-т заасан этгээдээс ярилцлага авч, нэмэлт мэдээлэл шаардаж болно.

## **ЗУРГАА. ШИЙДВЭР ГАРГАХ**

6.1. Хороо энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хүсэлт гаргагчийг тохиромжтой этгээд гэж үзвэл тохиромжтой этгээдийн дүгнэлтийг энэхүү журмын 4 дүгээр бүлэгт заасан заалт тус бүрээр гарган баталгаажуулсны үндсэн дээр хүсэлтийг шийдвэрлэнэ.

6.2. Энэхүү журмын 2.2-т заасан этгээд 4 дүгээр бүлэгт заасан шалгуурыг хангаагүй, эсхүл дараах үйлдэл гаргасан нь тогтоогдвол Хороо тохиромжтой бус этгээд гэж үзнэ. Үүнд:

6.2.1. Эцсийн өмчлөгчийг болон холбогдох бусад мэдээллийг нуун дарагдуулсан;

6.2.2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний гарал үүслийг худал мэдээлсэн;

6.2.3. Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн, худал ташаа мэдээлэл өгсөн;

6.3. Хүсэлт гаргагч тохиромжтой бус этгээд гэж тогтоогдвол холбогдох этгээдийг тухайн албан тушаалд томилуулахыг хориглоно.

### **ДОЛОО. ТОХИРОМЖТОЙ ЭТГЭЭДИЙН ҮНЭЛГЭЭ**

7.1. Хороо тохиромжтой этгээд мөн эсэхийг энэхүү журмын 2.2-т заасан этгээдэд энэ журмын 4 дүгээр бүлэгт заасан тохиромжтой байдлын шалгуурыг хангасан эсэхэд үнэлэлт, дүгнэлтийг өгнө.

7.2. Тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаж байгаа эсэхэд Хороо зайны болон газар дээрх хяналт шалгалтаар байнгын хяналт тавина.

7.3. Хороо тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаагүй эрх бүхий албан тушаалтныг тухайн албан тушаалаас нь өөрчлөх тухай мэдэгдлийг тухайн байгууллагад хүргүүлнэ.

7.4. Хороо тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгосны дараа тухайн тохиромжтой этгээдийн шаарлага хангахгүй болсон этгээдийн дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлнө.

### **НАЙМ. ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА**

8.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

--- 0 0 0 ---